



**ТӨВ АЙМГИЙН  
ЗУУНМОД СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2023 оны 05 сарын 16 өдөр

Дугаар A/173

Зуунмод

Олон улсын Хүүхдийн эрхийг хамгаалах  
өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын  
хэсэг байгуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.3, 15 дугаар зүйлийн 15.4.1, 16 дугаар зүйлийн 16.4.1, 17 дугаар зүйлийн 17.1.2 дах заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Зуунмод сумын хүүхэд багачуудын эрхийг хангах, тэдний авьяас, чадварыг хөгжүүлэх, оролцоо манлайллыг нэмэгдүүлэх зорилготой Олон улсын Хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг Зуунмод суманд тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай

- Ажлын хэсгийн дарга: -“Унагалдайн-Андуд” цэцэрлэгийн эрхлэгч
- Гишүүд:
  - Нийгмийн бодлогын мэргэжилтэн /Эрүүл мэнд, халамж, хөдөлмөр эрхлэлт, хөгжлийн бэрхшээлтэй иргэн хариуцсан/
  - Интернэт хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах ажилтан
  - Цэцэрлэгийн эрхлэгч нар
  - Сургуулийн нийгмийн ажилтнууд
  - Багийн зохион байгуулагч нар
  - Зуунмод сумын сурагчдын зөвлөл
- Нарийн бичгийн дарга: -Нийгмийн бодлогын мэргэжилтэн /Боловсрол, гэр бүл, хүүхэд залуучууд, сум, байгууллагын соёл урлаг болон нийтийн биеийн тамир хариуцсан/

2. Хүүхдийн эрхийг хамгаалах өдрийн арга хэмжээнд зорилтот өрхийн хагас, бүтэн өнчин, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг хамруулж, үйл ажиллагааг чанартай зохион байгуулж ажиллахыг Ажлын хэсгийн дарга, гишүүдэд үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт шинжилгээ үнэлгээ, дотоод аудит хариуцсан мэргэжилтэн (Д.Өнөрбаяр)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА  Ц.САРАНГЭРЭЛ   
